



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/231

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засгийн захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 31.1.6, Терроризмтой тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.4 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит IX хурлын 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөлийн аймаг дахь салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагааны заралд 3,800,000 (Гурван сая найман зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг Засаг дарга ерөнхий дансны "Ангилалдаагүй бусад зарцуулалт арга хэмжээ" данснаас гаргаж олгохыг аймгийн Ерөнхий санхүүч (Ц.Мөнхтуяа)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Г.Гандэлгэр)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД